

БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГА Р.ЭНХТАЙВАН

2024 оны 01 сарын 02

СУУРЬШЛЫН БҮСЭД ОРЖ ИРСЭН ЗЭРЛЭГ АМЬТДЫГ АВРАН ХАМГААЛАХ,
БАЙГАЛЬД СЭРГЭЭН НУТАГШУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ДААЛГАВАР

2024 оны 01 дугаар сарын 02

Улаанбаатар хот

1.	Үндэслэл	НХТЖҮЧ-6.2.3, НЗДҮАХ-5.3.2. Суурьшлын бүсийн тэлэлт, дэд бүтэц нэмэгдэхийн хэрээр Улаанбаатар хот орчмын зэрлэг амьтдын тархац нутаг хумигдах, нүүдлийн зам, амьдрах орчин хуваагдах, идэш тэжээлийн хомсдолд орох зэрэг сөрөг нөлөөллөөс үүдэлтэй зэрлэг амьтад хот суурин газар орж ирэх, гэмтэж бэртэх тохиолдлууд нэмэгдэж байна. 2018-2023 оны хугацаанд суурьшлын бүсэд гэмтэж бэртсэн болон идэш тэжээл хайн орж ирсэн зэрлэг амьтны дуудлага мэдээллийн тоо 3 дахин нэмэгдсэн бөгөөд нийт 412 удаагийн дуудлага хүлээн авч шаардлагатай арга хэмжээ аваад байна. Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт
2.	Зорилго	Улаанбаатар хотын суурьшлын бүсэд орж ирсэн зэрлэг амьтдыг авран хамгаалах, байгальд сэргээн нутагшуулах.
3.	Хамрах хүрээ	Нийслэлийн нутаг дэвсгэр
4.	Ажил гүйцэтгэлийн хугацаа	2024 оны 1 дүгээр сараас 12 дугаар сарын 10-ны өдөр
5.	Гүйцэтгэгч мэргэжлийн байгууллагын тусгай шаардлага	<ul style="list-style-type: none">- Ан амьтны мэргэжлийн эрх болон мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой бусад тусгай зөвшөөрөлтэй байх,- Мэргэжлийн байгууллагын хүрээнд зохион байгуулсан ажлын туршлага, танилцуулга бүхий холбогдох байгууллагын тодорхойлолт,- Гүйцэтгэх ажлын үйлчилгээтэй холбоотой хүний нөөц, мэргэжлийн боловсон хүчин, техник, туулах чадвар

		сайтай авто машин, амьтан барих, түр нойрсуулах эм хэрэгслийн мэдээлэл бүхий баримт - Амьтны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтын хангах
6.	Ажил үйлчилгээг гүйцэтгэхэд тавигдах аюулгүй ажиллагааны шаардлага	-Аюулгүй ажиллагааны тоног төхөөрөмж, анхан шатны эм, эмнэлгийн хэрэгсэлтэй байх ба эдгээрийг баримтжуулах.
7.	Хүлээн авах ажил үйлчилгээ	-Зэрлэг амьтдыг авран хамгаалах, байгальд сэргээн нутагшуулсан ажлын тайлан, холбогдох баримт мэдээлэл, - Зэрлэг амьтантай харьцах анхан шатны зөвлөмж бүхий цахим /постор/ мэдээлэл, - Байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нарт үйл ажиллагаа болон мэргэжлийн чиглэлээр сургалт зохион байгуулах, - Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин ажлыг сурталчлах.
8.	Санхүүжилтийн эх үүсвэр	Нийслэлийн төсөв / 2024 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал/
9.	Захиалагч байгууллага:	Нийслэлийн Байгаль орчны газар
10.	Хүрэх үр дүн:	Улаанбаатар хотын суурьшлын бүсэд гэмтэж бэртсэн болон бусад байдлаар орж ирсэн зэрлэг амьтадтай холбоотой дуудлага мэдээллийг мэргэжлийн байгууллага хүлээн авч шаардлагатай арга хэмжээ авна.

Хянасан:



БОЯБХХ-ийн дарга
Ц.Цолмонбаатар

Боловсруулсан:



БОЯБХХ-ын ахлах мэргэжилтэн
Т.Чингэл